

**“БАЯНТЭЭГ” ХК-ИЙН ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН
ЭЭЛЖИТ ХУРЛЫН ТЭМДЭГЛЭЛ**

2022 оны 04 сарын 14 өдөр

Арвайхээр сум

“Баянтээг” ХК-ийн хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурал 2022 оны 04 сарын 14-ний өдрийн 10:00 цагт Өвөрхангай аймгийн нутгийн удирдлагын ордны 203 тоотод эхлэв.

Хурлын дэгийн дагуу 10:20 хүртэл ирц бүртгэсэн.

А.Ишдорж: Хувьцаа эзэмшигчдийн хурлын дэгийг танилцуулав. Үүний дараагаар Тооллогын комисс хурлын ирцийн тогтоолыг танилцуулав. Компанийн ээлжит хуралд нийт саналын эрхтэй хувьцааны 93,54% буюу 236,277 ширхэг хувьцаа эзэмшиж буй 2 хувьцаа эзэмшигч оролцож тооллогын комиссоос хурлыг хүчин төгөлдөр гэж мэдэгдэж компанийн хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурал эхэлсэн.

Хурлын дарга хэлэлцэх асуудлуудыг танилцуулсан

1. Компанийн 2021 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайланг батлах
2. Компанийн 2021 оны Хөрөнгө оруулалтын төлөвлөгөөний хэрэгжилтийг батлах
3. Компанийн 2022 оны үйл ажиллагааны төлөвлөгөөг батлах
4. Компанийн 2022 оны Хөрөнгө оруулалтын төлөвлөгөөг батлах
5. Шахмал түлшний үйлдвэрийн хөрөнгө шийдвэрлэх
6. Төлөөлөн Удирдах Зөвлөхийн гишүүдийг сонгох
7. Бусад /Аудитын дүгнэлт, компанийн дүрмэнд өөрчлөлт оруулах, ажлын хэсэг байгуулах, санамж бичгийг дэмжих тухай/

Гүйцэтгэх захирал Н.Данзан: 2021 оны үйл ажиллагааны тайлан танилцуулав.

Д.Миеэгомбо: 2021 оны нэгдсэн төлөвлөгөөнд нүүрсний өртгийн талаарх төлөвлөгөө байгаа юу 2022 онд түлшний үнэ нэмэгдэж байгаа литр нь 3500 болох шинжтэй байгаа тул төлөвлөгөө хөдлөх байх.

Ю.Батсайхан: Шатахууны 2021 онд хөрс хуулалтан дээр ЭКГ-5А дангаараа ажилласан юмуу хөрс хуулалтан дээр түлш хэмнэсэн харагдаж байна энэ тухай тайлбар

Ю.Ариунтунгалаг: Шатахууны үнэ эхний хагас жилээр хямдхан үед аваад үнийн зөрүү гарсан

А.Ишдорж: Өөр асуух зүйл байхгүй бол тогтоолоо батлая

А.Ишдорж: Баянтээг өнгөрсөн онд нэмэх баланстай ажилласан, өр авлага өмнөх жилээс их байна өр авлагаа 0.1-0.3 хувиар хүү алданг тооцож авах хэрэгтэй байна. Хүү алданг тооцож авахгүй бол ашиг сонирхолын гэж үзнэ шүү, урд оны ХЭХурал дээр ярьж байсан гүйцэтгэх захиралд үүрэг өгч байна.

Н.Данзан: Бүх аж ахуйн нэгжэд албан тоот явуулсан байгаа, хамгийн их өртөй Хангамж өргөө ХХК л байгаа Пинган гэж компани он гаргаад төлнө гэсэн. Он гарсаар төлбөрөө төлсөн байгууллагууд байгаа жишээ нь: Өв-Баян Улаан ХХК гэх мэт

А.Ишдорж: дулааны мөнгө сар сардаа орж байгаа, алданг тооцсон байгууллага байна уу одоогоор

Д.Миеэгомбо: бүртгэл дээр алданг тусд нь яаж бүртгэж байна алданга чинь нөгөө хүн гэрээгээ зөрчиж байгаа гэсэн үг шүү

Ю.Ариунтунгалаг: алданг тооцсон байгууллага байхгүй байгаа

Д.Миеэгомбо: Хуулийн дагуу хариуцлага тооцох хэрэгтэй нүүрсний үнэ хямд байна яагаад өөр аймгаас нүүрс аваад байгаа вэ гэхлээр үнэ хямд учраас

Ю.Батсайхан: Аудитын тайлангаас асуух юм байна авлагаа яагаад дор дор нь тулгахгүй байна

Д.Миеэгомбо: Өмнөх ХЭХурал дээр яригдсан байгаа 5 жилээр хөндлөнгийн аудит хийлгэх гэж олон улсын зэрэглэлд тэнцэх хөндлөнгийн аудитаар

А.Ишдорж: Аудит хийлгэсэн байгаа интер аудитаар, энэ жилийн аудитаар хязгаарлалттай дүгнэлт гарсан байна хэд хэдэн асуудал орсон тамирчдад, санхүүгийн 100 жилийн ойд ТУЗ-ийн шийдвэрээр гарсан уу?

Н.Данзан: Төмөрхүлэгт 10 сая төгрөг дээр бол нөхөж ТУЗ-ийн шийдвэр гарна гээд гараагүй, санхүүгийн 100 жилийн ойд 9 сая төгрөг ТУЗ-ийн Нэмэхбаяр даргын үед гарсан

Д.Миеэгомбо: ТУЗ-ийн шийдвэргүйгээр мөнгө зарцуулсан нь таарахгүй байна. Алданг бол гэрээгээ байгуулаад гарын үсэг зурсан нь бол шүүхэд өг

Ю.Батсайхан: Нягтлан бодох бүртгэл дээр анхаарах, бодлогын баримт бичиг дээр алдаатай байгаад байгаа бол нэмэлт орон тоо батлаад сургалтанд хамрагдаад олон улсын стандартад нийцүүлээд явсан дээр байх гэсэн саналтай байна. Гүйцэтгэх захиралын хувьд уулын ажил дээр бол сайн ажиллаж байгаа

Н.Данзан: Гүйцэтгэлээр бол бульдозер 8 сард нийлүүлэх байсан хил хаалттай нийлүүлж чадаагүй байгаа том том тендерээ аймгийн худалдан авахаар зарлуулсан

А.Ишдорж: Бульдозероо түгээмэл хэрэглэгдэж байгаа техник байвал зүгээр өөр бол сэлбэг олдоц муу

Ю.Батсайхан: Хаагаад эцсийн дүгнэлт гараад нийлүүлэгч нартаа хэлсэн юмуу гэрээгээр нийлүүлэх хугацаа зөрчсөн бол хэрэггүй

Д.Миеэгомбо: Хугацаандаа нийлүүлээгүй бол хүчингүйш дээ

А.Ишдорж: Бульдозероо дахиж тендер зарлаад нийлүүлсэн дээр

А.Ишдорж: Хөрөнгө оруулалтан дээр өөр санал байна уу байхгүй бол 3 дах асуудал буюу 2022 оны үйл ажиллагааны төлөвлөгөө батлах талаар ярилцах

Н.Данзан: 2022 оны төлөвлөгөө танилцуулав

Д.Миеэгомбо: Нүүрсний борлуулалт 2021 онд гүйцэтгэлээрээ 230 мян/тн/ нүүрс борлуулсан байгаа бууруулмааргүй байна. Төлөвлөгөөн дээрээ 230 мян/тн/ гэж тусгаж өгмөөр байна. Нүүрсний үнэ нэмэх талаар саналтай байна. Үнийн судалгаа хийсэн юм байна уу

Н.Данзан: Ашигт малтмалын газраас авах гэсэн чинь заавал албан тоот явуулж авах ёстой юм байна лээ. Хэдэн газраас асуусан байгаа доод үнэ 58000 байна. Шатахууны үнэ нэмэгдээд байна түлш нөөцлөх сав 2 ширхэгийг авсан

Ю.Батсайхан: Бусад уурхайг бодвол манай нүүрсний илчлэг 6500 аас дээш байдаг нүүрсний үнэ өсгөхгүй л бол болохгүй түлш 1 литр нь 3500 болж байна. Тэсэлгээ хийнэ гэж яриад байгаа тэсрэх материалын зардал хэд болох уу. Нөөцийн сав санаа нь зөв байна дахиад 2 сав авч нэмэгдүүл.

Д.Миеэгомбо: Эдийн засаг талаасаа тутмаг байна энэ компанид

Н.Данзан: Үнийн тухай асуудал даргат танилцуулсан, таны яриад байгаа юм бол зөв эдийн засагч байхгүй

А.Ишдорж: 2022 он төлөвлөгөөн дээрээс юм асууя шатахуунаа хэдэн төгрөгөөр тооцож байгаа вэ арай бага байна литрийн үнэ 3500 төгрөгөөр төлөвлөсөн дээр юм байна. Шатахууны нөөцийн саваа нэмэгдүүл стандартын шаардлага хангасан байх, харилцаа холбоо юуны төлбөр вэ гар утасны төлбөр юмуу, хөдөлмөр хамгаалал яагаад нэмэгдсэн юм бэ. Тэсэлгээ хийх юмуу одоо байгаа өрмийн машинаа зарах юмуу ашиглахгүй байгаа бол.

Ю.Ариунтунгалаг: Интернэтийн төлбөр, хөдөлмөр хамгаалал бол нийт зардалын 1,5 хувиас багагүй байх ёстой

Ю.Батсайхан: Өрмийн машин бол зориулалтын биш нийлүүлсэн компанитай холбогдоод зарсан дээр байх

А.Ишдорж: Сүүлийн үеийн өрөм нь ямар үнэтэй байгаа вэ энэ өрмийн машинаа зарах хэрэгтэй юм байна.

Ч.Ууганбаяр: сүүлийн үеийн өрөм 200 саяаас дээш байсан

Д.Миеэгомбо: Цахилгааны үнэ нэмэгдэх гэж байгаа тог таслан хязгаарлан гэж байгаа цахилгааны үнээ яаж төлвөлсөн бэ

А.Ишдорж: Өрмийн машинаа худалдан борлуулах уу

Хувьцаа эзэмшигчид бүгд дэмжив.

Д.Миеэгомбо: Төлөвлөлтийг өмнөх оноос бууруулж төлөвлөхгүй баймаар байна. Эдийн засагч хэрэгтэй судалгаа байхгүй нүүрсний үнийг нэмэх

Ю.Батсайхан: Энэ жил үнэ нэмэх санал гаргалаач 2023 онд хэрэгжиж эхлэнэ, хөрс хуулалтаа бага хийж тэсэлгээний ажлаа сайн хийх, борлуулалтаа нэмэгдүүлэх хэрэгтэй нүүрсний үнээ нэмье зардалаа багасгая техник технологийн шинчлэл хийе.

А.Ишдорж: Хувьцаа эзэмшигчийн саналыг бодож үзлээ. Үнээ нэмэхээр борлуулалт буурна айл өрхөө яаж шийдэх вэ гэсэн асуудал гарч ирнэ. Зуухнууд халаалтын үнээ нэмнэ

Д.Миеэгомбо: Худалдан авалт хийгээл урамшуулал гэж юм гаргаж ирвэл хамгийн бага худалдан авалтаар болзол тавина гэрээний нөхцөлөөр

А.Ишдорж: Шатахуун литр 3500 аар тооцож төлөвлөх олборлолтоо 230 мянгаараа, Үнэ нэмэх тухай асуудалыг мэргэжлийн баг хуралдуулсаны дараа ТУЗ-ийн хурлаар хэлэлцэх.

Н.Данзан: Нэг санал байна төлөвлөгөөн дээр энэ онд хайгуул оруулсан байгаа 30 хувийн хийлгэсэн одоо 70 хувийг хийлгэх дутуу хийлгэж дуусгамаар байна.

А.Ишдорж: Хайгуулаа хийлгий төлөвлөгөөнд тусгаж

Ю.Батсайхан: 70 хувийн хайгуул хийлгэхийн тулд 2 жилд уян хатан байдлаар зохион байгуулая тендерийг 1 зарлаад он дамжуулаад

А.Ишдорж: Нарийнтээл сумын булаг сэргээх зардал 100 сая төгрөг төлөвлөгөөнд оруулая, бульдозероо дахиж зарлаад оруул

А.Ишдорж: Миний хувьд хайгуулаа бүрэн хийлгэмээр гэсэн саналтай байна 4 тэрбум төгрөгөөр төлөвлөгөөнд оруулий он дамжуулая.

Хувьцаа эзэмшигчид дэвжив.

А.Ишдорж: Төлөвлөгөөн дээр дүйцүүлэн нөхөн сэргээх гэж байдаг Нарийнтээл суманд 2 булаг байгаа нэг нь сэнжитэд байгаа нөгөөх нь цаад талд нь байгаа энэ 2 булаг дээр хөвийн зураг төсөл хийлгэж байгаа хажууд нь тэрбум мод тарих гээд энэ 2 булагын аль нэг дээр нь хөв хийх

Ю.Батсайхан: Хөв дээрээ багийн иргэдээс санал авсан дээр шүү тэгэхгүй бол мал орж үхнэ гээд асуудал гарч ирнэ.

Н.Данзан: Ард иргэд эсэргүүцээд байгаам байна лэ мал орж үхнэ гээд

Ю.Батсайхан: Сайн асууж шийдвэрээ гаргаарай

Н.Данзан: Хөв хийлгэх дээр 100 сая төгрөг оруулая

Хувьцаа эзэмшигчид дэмжив.

Ю.Батсайхан: 60 жилээ яах вэ

А.Ишдорж: Ном бол байх байх жижигхээн наадам хийх ажилчидаа шагналд тодорхойл

Н.Данзан: Ном хийлгэх засгийн газрын тогтоолоор хориглосон байгаа хэрэггүй байх

Д.Миеэгомбо: Номоор яахийн бэ тэрний оронд тээг уулынхаа төслийг нүүрсээр хийгээд шилэн дотор хийгээд дээр нь наашаа харсан логогоо хийгээд ажилчиддаа өгсөн дээр байх

Ю.Батсайхан: Логогоо шинэчилсэн дээр байх

А.Ишдорж: Хөрөнгө оруулалтан дээр санал байна уу

Ю.Батсайхан: Энэ шник гэж хуучин өрмийн машин дээр бол дэмий хэрэггүй хасах хэрэгтэй

Н.Данзан: Шникээ хасаарай Ариунтунгалагаа

Н.Данзан: Нарийнтээлд фургон автомашин авч өгнө гэж төлөвлсөн байгаа дууссан 7 сараас нааш ирэхгүй гэж байн

А.Ишдорж: ргобох авч өгөө туулах чадвар сайтай эвдрэл багатай

А.Ишдорж: Шахмал түлшний үйлдвэрийн хөрөнгө мөнгө шилжүүлэх гэж байна 1934211126 төгрөгийн хөрөнгө байна шахмал түлшийг Арвайхээрт нэг багт түлсэн утаа эрс буурсан

Ю.Батсайхан: Энэ асуудлыг хөндсөн аудит оруулах хэрэгтэй

Д.Миеэгомбо: Эхлээд махны үйлдвэр дараан нь шахмал түлшний үйлдвэрийн асуудал болсон 2016 оноос 2021 он хүртэл аудит оруулмаар байна олон улсын зэрэглэл бүхий аудитын газараар хөндлөнгийн аудит хийлгэх

А.Ишдорж: Ер нь бол хийлгэсэн гээд байгаа эндээс бол юм ойлгохгүй байгаа саяны хурал дээр яригдсан махны үйлдвэртэй холбоотой асуудлууд хил хаасантай холбоотой мах гаргаж чадахгүй ажил зогссон байгаа

Д.Миеэгомбо: Өмнө нь аудит хийлгэх гэхээр хийлгэхгүй ямар нэгэн аргаар саатуулаад байсан

А.Ишдорж: Би бас санал нэг байна аудит хийлгэх хэдэн төгрөг байдын тэрийн оруулж өгөөд хийлгий

Хувьцаа эзэмшигчид бүгд дэмжив

А.Ишдорж: Аудит хийлгэсэний дараа ШТҮ-ийн хөрөнгө мөнгөний талаар шийдий

Ю.Батсайхан: Гаргасан өгсөн авсан нь тодорхой болно

Аудитын дүгнэлтийн дараа Төлөөлөн Удирдах Зөвлөлөөр хэлэлцэж батлах

А.Ишдорж: Төлөөлөн Удирдах Зөвлөлийн гишүүдийг сонгох тухай гэсэн байна орон нутгийн зүгээс бол ТУЗ-ийн гишүүдэд өөрчлөлт оруулах хүсэлт байхгүй.

Ю.Батсайхан: “Шунхлай холдинг” ХХК-ийн зүгээс ТУЗ-ийн гишүүд хэвээр ажиллана

Хувьцаа эзэмшигчид ТУЗ-ийн гишүүдийг дэмжив

А.Ишдорж: Бусад асуудлын талаар

Ю.Батсайхан: Бусад асуудлын 1 дүгээрт компанийн дүрмэнд өөрчлөлт оруулах гэж байгаа тогтоолын төслийг гаргая

А.Ишдорж: Дараагийн бусад асуудалд нь Аудит хийлгэх тухай гэж байгаа тогтоолын төслийг боловсруулаад батлуулая

Ю.Батсайхан: Одоо нүүрсний үнэ нэмэх талаар

А.Ишдорж: Нүүрсний үнийг нэмэхдээ мэргэжлийн ажлын хэсэг байгуулаад дүгнэлт гаргуулаад дүгнэлтийг үндэслээд үнэ нэмэх

Д.Миеэгомбо: Ажлын хэсэг байгуулах, санамж бичгийг дэмжих тухай тогтоолын төсөл боловсруулах, шунхлайгаас бид 2 ороод санхүүгүүгийн 1 хүн байх, Данзан өөрөөр ороод ТУЗ-ийн даргаараа ахлуулая

А.Ишдорж: ажлын хэсэгийн бүрэлдэхүүнд

Ажлын хэсгийн ахлагч:

“Баянтээг” ХК-ийн ТУЗ-ийн дарга Ч.Гүнсэнхорол

Ажлын хэсгийн гишүүн:

Орон нутгийн өмчлөлийг төлөөлж Санхүү, төрийн сангийн хэлтсийн дарга Ц.Идэрсайхан

“Баянтээг” ХК-ийн Гүйцэтгэх захирал Н.Данзан

“Баянтээг” ХК-ийн ТУЗ-ийн гишүүд:

Ю.Батсайхан

Д.Миеэгомбо гэсэн хүмүүсийг оруулая.

Бусад асуудалыг хувьцаа эзэмшигчид бүгд дэмжив.

Хурлын дарга хурлын хааж үг хэлснээр хурал 15 цаг 35 минутад дуусав.

Тэмдэглэл хөтөлсөн:

ТУЗ-ийн нарийн бичиг

/ Л.Ган-Отгон /

Тэмдэглэл хянасан:

Хурлын дарга

/ Ч.Гүнсэнхорол /

